



## НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 30 өдөр

Дугаар A/1000

Улаанбаатар хот

Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах  
эрхийг хангаж, хуулийн хэрэгжилтийг  
зохион байгуулах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.3 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Байгаль орчны хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Захиргааны өрөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дүгээр 4.2.4, 4.2.5 дахь заалт, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, 27 дугаар зүйлийн 27.4.3 дахь заалт, 27.5 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 48.2.1, 48.2.2 дахь заалт, Газрын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсэг, 40 дүгээр зүйлийн 40.1.2 дахь заалт, 57 дугаар зүйлийн 57.1, 57.3, 57.4 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалт, 7.2 дахь хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.1, 35.1.2 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, 12.1.4 дэх заалт, 22 дугаар зүйлийн 22.2.1 дэх заалт, Иргэний хуулийн 502 дугаар зүйлийн 502.2 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 50 дугаар тогтоол, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны А-230/127 дугаар хамтарсан тушаалтын хавсралтаар батлагдсан "Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам", Дэд бүтцийн хөгжлийн сайд (хуучин нэрээр)-ын 2004 оны 130 дугаар тушаалаар баталсан "Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНБД 30.01.03"-ын 8.1. 8.6, 8.7 дахь хэсэг, Байгаль орчны хяналтын улсын ахлах байцаагийн 2023 оны 01/13-01/023-02 дугаартай дүгнэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хан-Уул дүүргийн 15 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах "Эм энд Жи констракшн" ХХК нь Сэлбэ-Дунд голын онцгой хамгаалалтын бүс, үерийн далан сувгийн хамгаалалтын зурvas газарт хууль зөрчиж барилга барьж байгаа нь нийслэл Улаанбаатар хотын иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулж, эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг алдагдуулж, нийтийн ашиг сонирхолд сергөөр нөлөөлөх эрсдэлтэй нөхцөл байдал үүсгэсэн тул хууль бус үйл ажиллагааг зогсоон, ашиглалтад ороогүй 2 барилгыг албадан буулгаж, газар чөлөөлөх ажлыг зохих журмын дагуу шуурхай зохион байгуулахыг Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/953 дугаар захирамжаар байгуулсан Ажлын хэсэгт үүрэг болгосугай.

2.Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтнуудад даалгасугай:

2.1.тус компанийд олгосон Архитектур төлөвлөлтийн даалгаврын холбогдох хэсгийг хүчингүй болгож, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Ерөнхий архитектор бөгөөд Хот байгуулалт, хөгжлийн газар (Ц.Тулга)-т;

2.2.барилга угсралтын үйл ажиллагааг зохих журмын дагуу зогсоохыг Нийслэлийн Хотын стандарт, хяналтын газар (Ц.Төмөрдүлам)-т;

1110204376

2.3. барилгыг албадан буулгахтай холбогдуулан орчны аюулгүй байдлыг хангаж, болзошгүй осол, дуу чимээ, доргилт, тоосжилтоос урьдчилан сэргийлэх ажлыг шуурхай зохион байгуулахыг Нийслэлийн Онцгой байдлын газар (А.Дашням), Нийслэлийн Хотын стандарт, хяналтын газар (Ц.Төмөрдүлам)-т тус тус;

2.4. барилгыг албадан буулгахтай холбогдон гарах зардлыг зохих журмын дагуу нийслэлийн төсвөөс гаргахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (И.Баатархүү)-т;

2.5. хэв журмыг сахиулж, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлж ажиллахыг Нийслэлийн Цагдаагийн удирдах газар (О.Ганбат)-т, цахилгаан, эрчим хүчний асуудлыг хариуцаж ажиллахыг "Улаанбаатар Цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК (Р.Дагдан)-д;

2.6. барилгын хог хаягдлыг зөөвөрлөхийг "Нийслэлийн Хот тохижилтын газар" ОНӨААТҮГ (Б.Мөнхцэцэг)-т, барилга албадан буулгах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллахыг нийслэлийн бүх шатны нутгийн захиргааны болон харьяа байгууллагуудын удирдлагуудад, хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба (М.Баяраа)-нд тус тус;

3. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Ж.Сандагсүрэнд үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ

Д.СУМЬЯАБАЗАР

